

## Онлайн тийз захиалга хийх заавар

Манай сайтаар дамжуулан, төлбөрийн картаа ашиглан та бүхэн нислэгийн тийзээ захиалж болох ба “Аэромонголиа” ХХК-ийн тийз борлуулах төвүүдээс худалдан авч болно. Тийз захиалах үйл явц нь хялбар бөгөөд дунджаар 5-10 минутыг зарцуулна. Эрхэм хэрэглэгч та тийз захиалга хийхийн өмнө та дараах хэдэн анхааруулгыг хүлээн авна уу.

- 1. Хэрв та онлайнгаар тийз захиалсан бол нислэгийн өдөр өөрчлөх, тийзээ буцаах зэрэг хүсэлтүүд тань хязгаарлагдмал болохыг анхаарна уу. Та Монгол улсын хаанаас ч тийз захиалсан тохиолдолд манай тийз захиалгын менежертэй холбогдож хүссэн үйлчилгээгээ авах боломжтой.  
Харин гадаадаас тийз захиалсан тохиолдолд манай компанийн тийз захиалгын менежер рүү электрон имэйл илгээх зарчмаар хүссэн үйлчилгээгээ авах боломжтой.*
- 2. 0-2 насны нярай хүүхдийн тийзийг онлайнгаар захиалах шаардлагагүй. Эцэг эх эсвэл итгэмжлэгдсэн асран хамгаалагч нь онлайнгаар тийз захиалсан тохиолдолд нисэх өдөрөө, нисэх онгоцны буудал дээр ирж манай бүртгэлийн ажилтнуудаас тийзийг захиалж авах боломжтой юм.*
- 3. Тийз захиалгын 3-р алхам дээр хэрэглэгч хувийн мэдээллээ оруулахдаа латин үсгээр бичихийг анхаарна уу. Жишээ нь: (Батхүү- Batkhuu), (ЧД:84022116 – ChD:84022116) гэх мэт.*

### Тийз захиалгын 5 алхамыг харуулав.

- 1. Нислэг хайх -> 2. Нислэг сонгох -> 3. Зорчигчийн мэдээлэл оруулах -> 4. Төлбөр хийх -> 5. Тийз авах**

Хэрэглэгч тийз захиалга хийж байх үедээ өөрийгөө аль алхам дээр явж байгаагаа хянах боломжтой бөгөөд хүссэн үедээ алхамаа буцааж болно.

### Товч заавар

Онлайн тийз захиалга хийхийн тулд эхлээд сонирхсон чиглэл, явах болон ирэх өдөр, зорчигчдын тоо болон нислэгийн ангиллыг заагаад “Чиглэл хайх” гэсэн сонголтыг дарна. Дараагийн хуудсанд Танд +/- 3 өдрийн сонголттойгоор хамгийн хямд нислэгүүдийг санал болгоно. Та нисэх өдрөө сонгосноор таны сонгосон өдөр ямар нислэг, ямар үнэтэй байгааг хүснэгтийн дээд буланд харуулна. Та нислэгийн үнэ дээр дарж тухайн нислэгийн үнэ, такс болон хураамжийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл бүхий хуудас нээгдэнэ. Та дээрх үнэ болон бусад нөхцлүүдийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд “Бүртгүүлэх” гэсэн товчыг дарна. Зорчигч хувийн мэдээллээ үнэн зөв оруулснаар дараагийн алхам буюу төлбөр хийх хэсэгт шилжинэ. Та виза картаа ашиглан төлбөрөө амжилттай хийснээр таны суудал баталгаажих ба таны бүртгүүлсэн и-мэйл хаягаар баталгаажуулах код танд очих болно. Энэ кодыг тэмдэглэн авч нисэх өдөрөө, нисэх буудал дээр авч очисноор тав тухтай манай нислэгээр зорчих эрхтэй болох юм.

### Дэлгэрэнгүй заавар

#### 1. Нислэг хайх

Нислэг хайх гэсэн энэ хэсэг нь 4 дэд хэсгээс бүрдэх ба дэд хэсэг бүр нь захиалагчийн хувьд чухал мэдээлэл байх юм. Та энэхүү хэсэгт өөрийн зорчих гэж буй нислэгийн чиглэл болон нисэх өдөр, зорчигчийн товч мэдээллийг оруулах, тийз бичих дүрэм, заавартай танилцах юм.

- **Хэзээ хаана** – Зорчих гэж буй нислэгийн чиглэл болон нисэх өдөрийг сонгоно.
- **Зорчигч** – Зорчигчийн иргэншил болон зорчигчийн төрөл, зорчих хүний суудлын тоо, төлбөр хийх мөнгөн тэмдэгтийн хэлбэр, суудлын зэрэглэл зэрэг мэдээллийг оруулна.
- **Байгууллага** – Энэ хэсэг нь “Аэромонголиа” ХХК-тай хамтран ажилладаг жуулчны байгууллага мөн бартерийн болон бэлэн бусаар төлбөр тооцоо хийдэг байгууллагуудад хамаарагдах юм. Тухайн байгууллагад өгөгдсөн нэр, нууц үгийг оруулж системийг цааш үргэжлүүлнэ. Энгийн зорчигчид энэхүү хэсгийг бөглөхгүй байж болно.
- **Мэдээлэл** – Энэхүү хэсэгт Онлайн тийз захиалах журам, такс хураамжтай холбоотой мэдээлэл, онлайн тийз захиалах заавар зэрэгтэй танилцаж болох юм.

## 2. Нислэг сонгох

Нислэг сонгох гэсэн хэсэгт зорчихыг хүссэн өөрт тохирох нислэгээ сонгож түүнд харгалзах тарифын задаргааг харах зэрэг хэсгүүд багтана.

- **Нислэг сонгох** – Таны хайсан нислэгийн өдрүүд +/- 3 өдрийн сонголттойгоор танд харагдах болно. Та тохирох нислэгийг сонгосноор танд тухайн нислэгийн Тийзийн үнэ нь хүснэгтийн зүүн дээд буланд харагдах болно. Задаргаа гэсэн хэсэгт дарснаар тийзийн үнийн задаргааг харуулах болно. Тийзийн үнийн задаргааг **Такс шимтгэлийн мэдээлэл** гэсэн хэсэгт илүү дэлгэрэнгүй тайлбарласан болно.
- **Мэдээлэл** – Энэхүү хэсэгт Онлайн тийз захиалах журам, такс хураамжтай холбоотой мэдээлэл, онлайн тийз захиалах заавар зэрэгтэй танилцаж болох юм.
- **Зөвшөөрөл** – Энэхүү хэсэг захиалагчийн нислэгийн өдөрөө зөв сонгосон эсэх мөн **мэдээлэл** гэсэн хэсгийн дүрэм журмыг хүлээн зөвшөөрч байгаа эсэхийг лавлах зорилгоор оруулсан болно.

## 3. Зорчигчийн мэдээлэл

Зорчигчийн мэдээлэл гэсэн хэсэгт захиалагч өөрийн хувийн мэдээллийг үнэн зөв бөглөх шаардлагатай бөгөөд дараах 4 дэд хэсгээс бүрдэнэ.

- **Зорчигч бүртгэл** – Энэ хэсэгт 3 зорчигч зэрэг бүртгэх тохиолдолд **Зорчигчийн мэдээллийг нээх 1, 2, 3** гэх мэтээр доош дараалан харагдах болно. Зорчигчийн мэдээллийг нээх гэсэн хэсэгт Зорчигчийн овог нэр, хүйс, гэх мэт мэдээллүүдийг оруулж өгнө. Үүнд анхаарах нэг зүйл нь Орон нутгийн чиглэлд нисэж байгаа тохиолдолд гадаад паспортын дугаарыг бөглөх шаардлагагүй. Харин олон улсын чиглэлд нисэх тохиолдолд заавал бөглөх ёстойг анхаарна уу.

***Хувийн мэдээллийг оруулахдаа латин үсгээр бичихийг анхаарна уу.***

- **Нэмэлт мэдээлэл** – энэ хэсэгт захиалга хийж буй захиалагчийн мэдээлэл байх болно. И-мэйл хаягаа үнэн зөв оруулах шаардлагатайг анхаарна уу. Энэхүү и-мэйл хаягаар таны захиалсан тийзийн мэдээлэл очих учраас анхааралтай зөв оруулаарай.

## 4. Төлбөр хийх

Төлбөр хийх гэсэн хэсэгт та өөрийн кредит картын мэдээллийг үнэн зөв оруулснаар таны төлбөр хийгдэх болно. Таны кардтай холбоотой аливаа асуудал нь “Аэромонголиа” ХХК-д хамаарагдахгүй

болно. Та төлбөрийн нөхцөл, бусад дүрэм журам болон зарим нэг хязгаарлалтуудыг хүлээн зөвшөөрч байгаагаа баталгаажуулах ба та төлбөрийн кардны өгөгдлүүдийг оруулахыг санал болгоно.



Хэрэв та төлбөрийн картаар тооцоо хийсэн бол, хэрэв таны кард ашиглалт амжилттай болвол суудал хадгалалт амжилттай хийгдсэн талаар мэдээлэл таны и-мэйл хаягаар хүргэгдэнэ.

## **5. Тийз авах**

Энэ хэсэгт таны төлбөр тооцоо амжилттай хийгдсэнээр таны тийз захиалга хүчинтэй болж таны и-мэйл хаяг руу баталгаажуулалтын код болон таны авсан тийзийн санамж илгээгдэх болно. Та баталгаажуулалтын кодыг тэмдэглэн авч нисэх өдөрөө, нисэх буудал дээр авч очисноор тав тухтай манай нислэгээр зорчих эрхтэй болох юм.

**Танд баярлалаа**

**"АЭРОМОНГОЛИА" ХХК 2011 он**